

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭЛЭН

АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙ ОНОШЛУУР, ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ”
ИННОВАЦИЙН ТӨСЛИЙН ТАЙЛАН (2021 ОН)

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

ПРОФ, ДОКТОР Б. БАТТӨР

Улаанбаатар хот

2021 он

ГАРЧИГ

АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙ ОНОШЛУУР, ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ” ИННОВАЦИЙН ТӨСЛИЙН ТАЙЛАН	3
АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ РЕКОМБИНАНТ ЭСРЭГТӨРӨГЧ БҮХИЙ ФЕРМЕНТ ХОЛБОХ ЭСРЭГБИЕМИЙН УРВАЛ (ФХЭБУ)-Н ЦОМОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ.....	4
АЖЛЫН МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ.....	4
ФХЭБУ- д хэрэглэгдэх урвалж, түүнийг бэлтгэсэн арга зүй.....	5
АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ ФХЭБУ-Н ЦОМГИЙН РЕКОМБИНАНТ ЭСРЭГТӨРӨГЧИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮР ДҮН	8
АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ РЕКОМБИНАНТ ЭСРЭГТӨРӨГЧ БҮХИЙ ТҮРГЭН ОНОШЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ	10
Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох рекомбинант эсрэгтөрөгч бүхий түргэн оношлуурын үйлдвэрлэлийн арга зүй.....	10
АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ ТҮРГЭН ОНОШЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮР ДҮН.....	12
ДИАМИН АЦЕТУРАТ БОЛОН КЮНАПИРАМИН СУЛЬФАТ ТАРИЛГЫН НУНТАГ ЭМҮҮДИЙН ТЕХНОЛОГИ НУТАГШУУЛАХ ТУРШИЛТ, СУДАЛГАА	14
ДИАМИН АЦЕТУРАТ БОЛОН КЮНАПИРАМИН СУЛЬФАТ ТАРИЛГЫН НУНТАГ ЭМҮҮДИЙН ТЕХНОЛОГИ НУТАГШУУЛАХ ТУРШИЛТ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН.....	16
КЮНАПИРАМИН СУЛЬФАТИЙН БЭЛДМЭЛИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ИДЭВХИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	20
СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ	26
ХАВСРАЛТ	28

“АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙ ОНОШЛУУР, ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ” ИННОВАЦИЙН ТӨСЛИЙН ТАЙЛАН (2021 ОН)

Төслийн удирдагч: Б. Баттөр ЭШТА, доктор (PhD), профессор

Төслийн гүйцэтгэгчид: Гүйцэтгэгчид:

1. Б.Батцэцэг, ЭШТА, доктор (PhD), профессор
2. П.Мягмарсүрэн ЭШДэд Ажилтан, доктор (PhD)
3. Б.Даваасүрэн, ЭШДэд Ажилтан, доктор (PhD)
4. О. Банзрагчгарав, ЭШДэд Ажилтан,, доктор (PhD)
5. С. Наранцацрал, ЭШДэд Ажилтан, магистр
6. Б. Энхтайван, ЭШДэд Ажилтан, магистр
7. Т. Амгаланбаатар, ЭШДэд Ажилтан, магистр
8. М. Золжаргал, ЭШДэд Ажилтан, магистр
9. Б. Давхарбаяр, ЭШДад Ажилтан, магистрант
10. Д. Мөнхгэрэл, ЭШДад Ажилтан, магистрант

Төслийн зорилго, зорилт, төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Адууны нийлүүлгийн өвчнийг оношлогоо болон эмчилгээний бэлдмэлүүдийг дотооддоо үйлдвэрлэж, орон нутгийн мал эмнэлгүүдийн хэрэгцээг 100% хангах зорилго тавьж байгаа бөгөөд төслийг амжилттай хэрэгжүүлснээр доорхи үр дүнг хүлээлгэн өгнө.

1. Орчин үеийн биотехнологийн дэвшил дээр суурилсан ФХЭБУ-ын оношлуурын цомогийн үйлдвэрлэж УМЭАЦТөв лаборатори болон аймаг нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад нийлүүлэн дотоодын хэрэгцээг хангана.
2. Сум орон нутгийн мал эмнэлгийн нэгжийн эмч нар ашиглах боломжтой түргэвчилсэн оношлогооны тестийг төслийн нийт хугацаанд 10000- аас доошгүй үйлдвэрлэж өвчний тархалт болон халдварлалт өндөртэй аймаг, сумын 200- аас доошгүй сумын мал эмнэлгийн нэгж болон хувийн мал эмнэлэг, малын эмч нарт нийлүүлнэ.
3. Адууны нийлүүлгийн өвчнийг эмчлэх импортын эм бэлдмэлүүдтэй ижил үйлдэл бүхий эмийн бэлдмэл үйлдвэрлэж зах зээлд нийлүүлнэ.

АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ РЕКОМБИНАНТ ЭСРЭГТӨРӨГЧ БҮХИЙ ФЕРМЕНТ ХОЛБОХ ЭСРЭГБИЕМНИЙН УРВАЛ (ФХЭБУ)-Н ЦОМОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

АЖЛЫН МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ

Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ-ын цомгийн шинжилгээний арга
Үйлдвэрлэлийн нэг удаагийн дамжлагаар бэлтгэсэн адууны нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ-ын цомгийг нэг цуврал гэнэ. Нэг цувралын рекомбинант эсрэгтөрөгч суулгасан 96 үүр бүхий полистрол урвалын хавтан, угаагч уусмал, шингэлэгч, өнгө олгогч, хоёрдогч эсрэгбием, эсрэг, сөрөг хяналт бүхий цомгийг бэлтгэн адууны нийлүүлгийн өвчний оношлогоонд хэрэглэхээр хүрэлцэхүйц хэмжээгээр сорилд авна.

Мэдэрхүйн үзүүлэлт: Гадаад байдал, бүтцийг мэдрэхүйн эрхтнээр тодорхойлно. Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ-ын цомог нь рекомбинант эсрэгтөрөгч суулгасан 96 үүр бүхий хавтан, угаагч уусмалын савласан нунтаг, 2 мл-ийн хэмжээтэй цодонд тус тус савласан 2 догч эсрэгбием, хяналтын эерэг болон сөрөг ийлдэс, субстрат буюу өнгө олгогч ABTS-ийн буфер болон ABTS-ийн шахмал, урвал тавих заавар зэргийг агуулсан хайрцагтай байна.

Савлалтын хэмжээ: Рекомбинант эсрэгтөрөгч суулгасан 96 үүр бүхий 1 хавтан нь гадуураа шингэн нэвтрүүлэхгүй ууттай байна. Угаагч уусмалын нунтаг 1 ширхэг, 2 догч эсрэгбием 1 цодон, субстрат ABTS-ийн буфер 10 мл агуулсан цодон болон ABTS-ийн шахмал 1 ширхэг, хяналтын эерэг ийлдэс 1 цодон, хяналтын сөрөг ийлдэс 1 цодон зэргийг агуулсан хайрцагтай байна.

Оношлогооны эсрэгтөрөгч: *T. equiperdum*-ийн GM6 генийн 4 тандем давталтыг ашигласан рекомбинант эсрэгтөрөгчийг 5'-GGA TCC ATG GAG CTT GCTAAA-3' болон 5'-GAA TTC STA ATG TGA ATG CTC-3' праймер ашиглан ПГУ-аар олшруулаад Bam HI болон Eco RI таслагч энзимээр pGEX-6P-1 плазмидад оруулж, *E. coli* –ийн BL21 эсэд трансфекци хийсний дараагаар SOB тэжээлт орчинд ургуулсан. *rTqGM6-4r* уургийг GST bead ашиглан ялган авсан бөгөөд PreScission protease ашиглан GST уургаас салган авч концентрацийг BCA kit ашиглан тогтоосон.

Хоёрдогч эсрэгбием буюу конъюгат: rTqGM6-4r эсрэгтөрөгчийн эсрэг туулайнаас ялган авсан поликлональ эсрэгбием.

Субстрат: өнгө олгогч ABTS ашиглах бөгөөд субстратын буферыг тусгайлан савлаж, цомогт оруулсан.

Нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ тавих аргачлал

Рекомбинант антиген ФХЭБУ протокол

1. 96 үүртэй урвалын хавтанд эсрэгтөрөгчөө [rTe6G4] суулгах: Эсрэгтөрөгчийг урвалын хавтангийн үүр тус бүрт 2 мг/мл байхаар тооцон бэхлэгч буфер (Coating buffer)- ээр шингэлэн үүр тус бүрт 100 мкл- ийг хийгээд тасалгааны температурт 4 цаг тависан.
2. Угаах: Урвалын хавтан угаагч (Thermo microplate washer) машинд урвалын хавтангийн үүр тус бүрийг 200 мкл- ээр угаагч буфер [1x PBS]- ээр 3 удаа угаасан.

3. Блокинг: Фосфатын буферт 3%- ийн тосгуйжүүлсэн сүү нэмээд урвалын хавтангийн үүр тус бүрт 200 мкл- ийг хийж. 37⁰С- д 2 цаг тависан.
4. Угаах: Урвалын хавтан угаагч (Thermo microplate washer) машинд урвалын хавтангийн үүр тус бүрийг 200 мкл- ээр угаагч буфер [1x PBS]- ээр 3 удаа угаасан.
5. Шинжлэх ийлдэс болон хяналтын ийлдсийг 1:200- аар 3%- ийн тосгуйжүүлсэн сүүнд шингэлэн урвалын хавтангийн үүр тус бүрт 100 мкл- ийг хийж 37⁰С- д 2 цаг тависан.
6. Угаах: Урвалын хавтан угаагч (Thermo microplate washer) машинд урвалын хавтангийн үүр тус бүрийг 200 мкл- ээр угаагч буфер [1x PBS]- ээр 3 удаа угаасан.
7. Конъюгат буюу хоёрдогч эсрэгбиеийг (Protein G-HRPO) 1:5000- аар 3%- ийн тосгуйжүүлсэн сүүнд шингэлэн урвалын хавтангийн үүр тус бүрт 100 мкл- ийг хийж 37⁰С- д 1 цаг тависан.
8. Угаах: Урвалын хавтан угаагч (Thermo microplate washer) машинд урвалын хавтангийн үүр тус бүрийг 200мкл- ээр угаагч буфер [1x PBS]- ээр 3 удаа угаасан.
9. Өнгө өгөгч уусмалыг урвалын хавтангийн үүр тус бүрт 100 мкл- ийг хийж 37⁰С- д 30 мин тависан. Өнгө өгөгч уусмалыг нэмэхдээ мөн нэмсний дараа гэрлээс хамгаалсан.
10. Хугацаа болмогц хавтанг ФХЭБУ-ийн хавтан уншигч [Thermo multiskan fc] машины 405 нм долгионы уртад уншуулж гарсан тоон утгийг [Microsoft excel] программ ашиглан график байгуулан шинжилсэн.

Босго таньцийг олох арга.

“Cut-off= mean value (of A1+D1) x 3

Cut-off – Босго таньц.

Бодит утга (A1+D1)– сөрөг дээж x3– сөрөг дээжийн нийлбэрийг 3- аар үржүүлэн гарсан тоон утгаар босго таньцыг тогтоосон.

ФХЭБУ- д хэрэглэгдэх урвалж, түүнийг бэлтгэсэн арга зүй

Эсрэгтөрөгч: Нийлүүлгийн өвчний үүсгэгч *T. equiperdum* - г оношлох рекомбинант [rTq6G4].

1. Бэхлэгч буфер: Coating buffer (0.1M carbonate-bicarbonate buffer, pH9.6)

Na₂CO₃ 0.16 гр

NaHCO₃ 0.29 гр

Ариутгасан Нэрмэл ус 100 мл (pH-9.6) байна.

2. Угаагч уусмал: (Washing buffer) 0.05% [Tween-20] Фосфатын буферт (pH 7.2)

NaCl 8 гр

KCl 0.2 гр

Na₂HPO₄ 1.44 гр

KH₂PO₄ 0.24 гр

800мл Нэрмэл усанд уусгахад (pH-7.2) байсан. Дээр нь 0.5 мл (TWEEN-20) нэмж 1 литр хүртэл нэрмэл ус хийсэн.

3. Блокинг: (Blocking buffer) 3%- ийн тосгуйжүүлсэн сүү, фосфатын буфер

Тосгүйжүүлсэн сүү 3 гр
Фосфатын буфер 100 мл

4. Хоёрдогч эсрэгбием буюу коньюгат: (Protein G- HRPO) 3%- ийн тосгүйжүүлсэн сүү-
фосфатын буфер

Блокинг буфер 1 мл
Угаагч уусмал 9 мл

Өнгө өгөгч буюу субстрат уумалын хэмжээг 1- аар хүснэгтэнд үзүүлэв.

1-р хүснэгт


Өнгө олгогч уусмал буюу субстрат

0.2M Na₂HPO₄·12H₂O	0.1M anhydrous citric acid	pH	Total ABTS buffer
51.4 мл	48.6 мл	5.0	100 мл
102.8 мл	97.2 мл	5.0	200 мл
154.2 мл	145.8 мл	5.0	300 мл


Бэлтгэсэн ABTS буферийг тасалгааны нөхцөлд хадгалж болно. Урвалын хавтанд өнгө олгогчийг хийхийн өмнө 1 таблет ABTS/10мг/ нэмээд үүн дээр 25мкл 30% H₂O₂-г нэмж 100мл өмнө нь бэлтгэсэн ABTS буфер нэмнэ. Өнгө олгогчийн бэлтгэхдээ шууд гэрлээс хамгаалж мөнгөн цаасаар ороож урвалд ашиглана.

Рекомбинант эсрэгтөрөгч гарган авах аргачилал, урвалын хавтанд рекомбинант эсрэгтөрөгчийг бэхлэх аргачилалыг 1-р схемээр үзүүлээ.

Адууны нийлүүлгийн өвчний ФХЭБУ-ын цомгийн үйлдвэрлэл



Рекомбинант уураг бэхжүүлж бэлтгэсэн хавтанг ФХЭБУ бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн цомог бэлтгэх нь



АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ ФХЭБУ-Н ЦОМГИЙН РЕКОМБИНАНТ ЭСРЭГТӨРӨГЧИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮР ДҮН

ФХЭБУ-н цомгийн рекомбинант эсрэгтөрөгчийн үйлдвэрлэлийн үр дүн: Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох рекомбинант эсрэгтөрөгч бүхий Фермент холбох эсрэгбиеийн урвалын нийт 45 цомогийг үйлдвэрлэн Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторит (МЭЭСБУЛ) үйлдвэрлэлийн нэг удаагийн цувралын оношлууруудыг шалгуулан баталгаажуулсан. 2019, 2020, 2021 онд МЭЭСБУЛ-ээр шалгуулсан сорилтын дүн, Шинжээчийн дүгнэлтийг 1, 2-р хавсралтаар орууллаа.

Үйлдвэрлэсэн оношлууруудаас 21 аймгуудийн (УМЭАЦТЛ, Хил хамгаалах Ерөнхий газрын Мал эмнэлгийн лаборатори, Нийслэлийн мал эмнэлгийн газар, Хэнтий, Увс, Орхон, Өвөрхангай, Архангай, Дорнод, Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр, Сүхбаатар, Төв, Өмнөговь, Ховд) мал эмнэлгийн лабораторит нийлүүлсэн болно.



1-р зураг: Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ-ын цомгийг орон нутгийн мал эмнэлгийн лабораторийн ийлдэс судлаач эмч нарын гарт хүргэв.

Төслийн хүрээнд үйлдвэрлэсэн оношлуурын цуврал бүрээс МЭЭСБУЛ- т шалгуулах зорилгоор 1- 2 цомгийг зарлагдаж байна. Уг цомог нь рекомбинант эсрэгтөрөгчийг бэхлэсэн 96 үүр бүхий полистрол нэг хавтан, эерэг, сөрөг ийлдэс, 2догч эсрэгбием, өнгө олгогч уусмал, угаагч уусмал зэргийг багтаан хайрцагласан савлагаатай.

Үйлдвэрлэсэн оношлуурын нийлүүлсэн мэдээлэл

МЭЭСБУЛ- ийн шалгуулан баталгаажуулалт хийгдсэн ФХЭБУ-ын оношлууруудын цувралуудыг 2019, 2020, 2021 онд 21 аймаг, нийслэл, Улсын төв лабораториудад нийлүүлсэн мэдээлэлийг 1-р хүснэгтээр харуулав.

Уг төслийн хүрээнд Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ- ын цомгийг 21 аймаг, Нийслэлийн мал эмнэлэг, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторит нийт 102 цомог (1 цомог нь 96 дээж шинжлэх)- ийг нийлүүлэв.

№	Нийлүүлсэн аймгуудын лаборатори	Нийлүүлсэн цомог тоо		
		2019	2020	2021
1	УМЭАЦТЛаборатори	1	1	10
2	Нийслэлийн мал эмнэлгийн газар	1	1	10
3	Завхан аймгийн лаборатори	0	0	2
4	Хэнтий аймгийн лаборатори	1	1	2
5	Говь-Алтай аймгийн лаборатори	0	0	2
6	Дархан-Уул аймгийн лаборатори	0	0	2
7	Увс аймгийн лаборатори	1	1	2
8	Орхон аймгийн лаборатори	0	1	2
9	Өвөрхангай аймгийн лаборатори	0	1	2
10	Архангай аймгийн лаборатори	0	1	2
11	Дорнод аймгийн лаборатори	1	1	5
12	Баянхонгор аймгийн лаборатори	0	1	2
13	Хөвсгөл аймгийн лаборатори	0	1	3
14	Сэлэнгэ аймгийн лаборатори	1	1	2
15	Булган аймгийн лаборатори	0	1	2
16	Дундговь аймгийн лаборатори	0	1	2
17	Дорноговь аймгийн лаборатори	1	1	8
18	Говьсүмбэр аймгийн лаборатори	1	4	2
19	Сүхбаатар аймгийн лаборатори	1	1	2
20	Төв аймгийн лаборатори	0	1	2
21	Өмнөговь аймгийн лаборатори	1	0	2
22	Баян-Өлгий аймгийн лаборатори	1	0	2
23	Ховд аймгийн лаборатори	1	0	2
нийт		12	20	70

АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ РЕКОМБИНАНТ ЭСРЭГТӨРӨГЧ БҮХИЙ ТҮРГЭН ОНОШЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох рекомбинант эсрэгтөрөгч бүхий түргэн
оношлуурын үйлдвэрлэлийн арга зүй

Рекомбинант эсрэгтөрөгч (rTeGM6-4r) бэлтгэх арга зүй

Оношлогооны эсрэгтөрөгч: rTeGM6-4r: 4 давталт бүхий rTeGM6-4r уургийн генийг Glutathione S transferase уургийн гентей холбоходоо дунд precision protease ферментийн таслах байрлал оруулан консрукц хийсэн бөгөөд уг рекомбинант уурагаа *Escherichia coli*-д нийлэгжүүлсэн. Энэхүү уургаа glutathione sepharose 4B-г ашиглан ялган авахдаа precision protease хэрэглэн rTeGM6-4r цэврээр ялган авсан. *T. equiperdum*-ийн GM6 генийн 4 тандем давталтыг ашигласан рекомбинант эсрэгтөрөгчийг 5'-GGA TCC ATG GAG CTT GCTAAA-3' болон 5'-GAA TTC STA ATG TGA ATG CTC-3' праймер ашиглан ПГУ-аар олшруулаад Bam HI болон Eco RI таслагч энзимээр pGEX-6P-1 плазмидад оруулж, *E. coli* –ийн BL21 эсэд трансфекци хийсний дараагаар SOB тэжээлт орчинд ургуулсан. rTqGM6-4r уургийг GST bead ашиглан ялган авсан бөгөөд PreScission protease ашиглан GST уургаас салган авч концентрацийг BCA kit ашиглан тогтоосон.

Конъюгат. rTeGM6-4r уургийг энгийн фосфатын буферт диализ хийж ялган авсан буферээс цэвэрлээд, дараа нь уургийн концентрацыг 300 мкг/мл хүртэл нь шингэлээд 1мл ийг авч 10 мл алтаны коллойд дээр нэмж хольж, уг холимогоо тасалгааны температурт 10 минут хөдөлгөлгүйгээр инкубаци хийнэ. Дараа нь 5% polyethylene glycol 100мкл, 10% үхрийн ийлдсний альбумин 1 мл –г тогтворжуулах зорилгоор нэмнэ. Уг холимогоо 10000 rpm хурдаар 30 минут центрифугидээд супернатантын 90%-г асгаад тунадасыг үлдсэн супернатантад соникатор ашиглан дахин уусгаад 0.5% үхрийн ийлдсний альбумин, 0.05% polyethylene glycol агуулсан фосфатын буферт угааж мөн супернатантын 90%-г асгаад тунадасыг дахин уусгана. Уг уусмалаа 20 дахин шингэлж 520 nm долгионы уртад гэрлийн шингээлтийг хэмжинэ. Уг хэмжсэн гэрлийн шингээлт 0.5 болтол нь 0.5% үхрийн ийлдсийн альбумин, 0.05% polyethylene glycol агуулсан фосфатын буферын уусмалаар шингэлнэ. Энэхүү шингэлсэн конъюгатаа, 0.05% полиэтиленгликол, 3.5% сахарозын агуулсан 20 mM tris-HCl pH8.2 уусмалаар шингэлээд шилэн утаслаг мембранд шингээнэ.


rTeGM6-4r эсрэг туулайн IgG бэлтгэх арга зүй: 1 мл rTeGM6-4r Titer Max Gold 1 ml адьюванттай хольж туулайн нурууны арьсанд тариад 14 хоногийн дараа өмнөхтэй адил хэмжээгээр фрейндийн бүрэн бус адьюванттай тарьсан. Үүний дараа rTeGM6-4r суурилсан ELISA-гаар ийлдэсдэх эсрэг биеийн идвэхийг шалгана. Сүүлчийн тарилгаас 14 хоногийн дараа туулайн цусны ийлдсийг авч aMAbTrap kit (Sigma-Aldrich, St. Louis, USA) ашиглан тухайн цомгийн үйлдвэрийн зааврын дагуу IgG ялган авсан. Ялган авсан эсрэг биеийг концентрацыг тодорхойлж фосфатын буферээр диализ хийсний дараа хэрэглэх хүртэл –80°C –д хадгалана.

Нитроцеллюлозын мембранд rTeGM6-4r, rTeGM6-4r эсрэг туулайн IgG -г бэхлэх арга зүй: Ялган цэвэршүүлсэн эсрэгтөрөгчийг 1000 мг/мл, эсрэг биеийг 0.5 мг/мл концентрацитайгаар авч BioDot Biojet 3050 Quantidispenser нитроцеллюлозын мембранд шүршиж, мембраныг 50°C-т 30 минутын турш хатаагаад 0.5% казеин агуулсан борын хүчлийн буферт 30 минут инкубаци хийнэ. Эндээс мембраныг гарган авч 0.05% натрихолат, 0.5% сахароз агуулсан tris-HCl –оор 30 минутын турш угаагаад хатаана.

Иммунохроматографийн тестийг угсарч бэлтгэх адууны ийлдсэн дэх өвөрмөц эсрэг биеийг тодорхойлох арга: Хатуу наалдамхай цаасан дээр нитроцеллюлозын мембраныг эхлэн нааж, энэ мембранаа даруулан коньюгат шингээсэн шилэн утаслаг мембраныг наана. Дээр нь нэмэлт болгон дээж дусаах цаас, дээж соруулах цаасыг нааж бэхлэн тус бүрийг нь 3 mm өргөнтэйгээр BioDot cutter цаас зүсэгчийг ашиглан зүсэж бэлтгэсэн.

Иммунохроматографын тест ашиглах арга зүй:

1. Өвчтэй буюу сэжигтэй адуунаас бодисгүй хуруу шилэнд адуу тус бүрээс цус авна.
2. Авсан дээжээ центри фугдэж (Cole-Parmer) ийлдсийг ялгаж, ийлдэс тус бүрээс (50µl)-ийг авна.
3. Рекомбинант эсрэг төрөгч бүхий түргэн оношлогооны тест (ICT) дээрээ дусаана.
4. 10-15 минутын дараа 1x PBS уусмалыг (50µl)-ыг нэмэж дусаана.
5. 10-15 минутын дараа 1x PBS уусмалыг (50µl)-ыг нэмэж дусаана.



Схем 2: ИХТ-ийг хэрэглэх дараалал, тест ажиллах зарчим

АДУУНЫ НИЙЛҮҮЛГИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ ТҮРГЭН ОНОШЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮР ДҮН

Түргэн оношлуурын эсрэгтөрөгч болох рекомбинант эсрэгтөрөгчийн үйлдвэрлэлийн үр дүн: Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох рекомбинант эсрэгтөрөгч бүхий Түргэн оношлуурыг нийт 10000 ширхэгийг үйлдвэрлэн Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторит (МЭЭСБУЛ) үйлдвэрлэлийн нэг удаагийн цувралын оношлууруудыг шалгуулан баталгаажуулсан. Баталгаажилтын дүгнэлтүүдийг 2019 болон 2020 оны сорилтын дүн, шинжээчийн дүгнэлтийг 3, 4-р хавсралтад оруулав.

Оношлуурыг 20 ширхэгээр мөнгөлөг уутан уутлан 5 багц ууттай оношлуурыг 1 хайрцагт хийж 100 ширхэгээр МЭҮФӨ-ийн дагуу хайрцаглан аймаг тус бүрт 200 ширхэгээс 500 ширхэгээр хуваарилан нийлүүлсэн болно.



2-р зураг: Түргэн оношлуурын савлагдсан байдал.

Үйлдвэрлэлийн явцад лабораторийн нөхцөл, зарим бодисын нийлүүлэлт, техникийн алдаанаас (угсарсан оношлуурын хирчилт, зүсэлтийн үед урагдах, далий зүсэлт) хамааран 1000 ширхэг орчим оношлуурын хаягдал гарч байсан.

Үйлдвэрлэсэн оношлуурын нийлүүлсэн мэдээлэл

Хүснэгт 3

№	Нийлүүлсэн аймгуудын лаборатори	Нийлүүлсэн он тоо ширхэг		
		2019	2020	2021
1	УМЭАЦТЛаборатори	100	200	0
2	Нийслэлийн мал эмнэлгийн газар	300	300	0
3	Завхан аймгийн лаборатори	300	300	100
4	Хэнтий аймгийн лаборатори	300	300	100
5	Говь-Алтай аймгийн лаборатори	200	200	100
6	Дархан-Уул аймгийн лаборатори	200	200	100
7	Увс аймгийн лаборатори	200	200	100
8	Орхон аймгийн лаборатори	400	380	100
9	Өвөрхангай аймгийн лаборатори	200	200	100
10	Архангай аймгийн лаборатори	300	300	100
11	Дорнод аймгийн лаборатори	300	300	0
12	Баянхонгор аймгийн лаборатори	300	150	100
13	Хөвсгөл аймгийн лаборатори	300	300	100
14	Сэлэнгэ аймгийн лаборатори	300	300	100
15	Булган аймгийн лаборатори	200	300	100
16	Дундговь аймгийн лаборатори	300	300	100
17	Дорноговь аймгийн лаборатори	300	300	100
18	Говьсүмбэр аймгийн лаборатори	300	300	0
19	Сүхбаатар аймгийн лаборатори	300	500	100
20	Төв аймгийн лаборатори	300	300	100
21	Өмнөговь аймгийн лаборатори	200	300	100
22	Баян-Өлгий аймгийн лаборатори	200	300	100
23	Ховд аймгийн лаборатори	200	200	100
НИЙТ		6000	6430	2000

Үйлдвэрлэсэн адууны нийлүүлгийн өвчнийг оношлох “Түргэн оношлуур”- ыг 21 аймгийн мал эмнэлгийн лабораторит 2019- 2021 онуудад нийт 14430 ширхэг түргэн оношлуурыг нийлүүлсэн болно.

**ДИАМИН АЦЕТУРАТ БОЛОН КЮНАПИРАМИН СУЛЬФАТ ТАРИЛГЫН
НУНТАГ ЭМҮҮДИЙН ТЕХНОЛОГИ НУТАГШУУЛАХ ТУРШИЛТ, СУДАЛГАА
“Кюнапирамин сульфат- Qiunarygamine sulphate” тарилгын уусмал бэлтгэсэн
технологийн судалгааны арга зүй**

Адууны нийлүүлгийн өвчний үүсгэгчийн эсрэг өндөр идэвхитэй Кюнапирамин сульфат- Qiunarygamine sulphate -ийн 97.5%-аас дээш цэвэршилттэй хуурай нунтаг 2 гр найруулахаар тооцон савлаж эмийн уусгагч шингэн 20 мл давхар нэрмэл усыг ариун нөхцөлд савлан бэлтгэв. Гол үйлчлэгч хуурай бодисыг 2.0000 гр- аар жинлэн авч урьдчилан бэлтгэсэн цодонд савлан битүүмжилж хэт ягаан туяаны (UV) гэрлээр үйлчилж ариутгасан (Т.Р. Blunt (1842 -1929).

UV гэрлээр ариутгах багаж нь дээрээс, араас, хажуугаас гэсэн 3 байршилаар нэгэн зэрэг болон хэсэгчилсэн байдлаар сонгож үйлчлэх боломжтой бөгөөд мөн ариутгах хугацааг тохируулах тохируулгатай байх шаардлагатай.

“Кюнапирамин сульфат- Qiunarygamine sulphate” эмийн ариун чанарын судалгааны арга зүй: UV гэрлээр ариутгах багажны дээрх 3 нөхцөлд 10, 15, 20 минутанд нөхцөл бүрд, минут бүрд тус бүр 5 савыг ариутгана. Найруулах шингэн нь нэрмэл ус байх бөгөөд 20 мл-ээр савлан автоклаваар 121 °C-д 15 минут ариутгана.

Рентген шарах төхөөрөмж (RS 1800 Q4)- ийн 160 кэВ энергитэй рентген цацрагаар 20 минут болон 25 минут бүрт 8-10 савыг шарлага хийж ариутгана.

“Кюнапирамин сульфат- Qiunarygamine sulphate” тарилгын нунтаг эм болон найруулах шингэний ариун чанарын шинжилгээний арга зүй: Бэлтгэсэн хувилбаруудынхаа ариун чанарыг уламжлалт аргаар буюу TSA, TSB, Сабуро, TG-д суулгалт хийн тасалгааны температурт болон термостатын 37 °C-т 7 хоног тавьж, мөн хувилбаруудыг мембран шүүлтүүрийн арга буюу Thioglycollate- тай орчин, Сабурогийн орчинд суулгалт хийн тасалгааны температурт болон термостатын 37 °C-т 7 хоног тавьж тус тус шалгалаа. Харин найруулах шингэний ариун чанарыг TSA, TSB, Сабуро, TG-д суулгалт хийн тасалгааны температурт болон термостатын 37 °C-т 7 хоног тавьж шалгаж судалгааны ажлын 3 удаагийн давталттай хийнэ.

Грамын арга бактер будах арга зүй: Туршилтын цувралаар бэлтгэсэн дээрх эмүүдийн ариун чанарыг шалгаж тусгай тэжээлт орчинд ургуулсан дээжүүдийг дараах арга зүйн дагуу шинжлэв.

1. Шинжилгээний цийдмэгээс 10 мкл-ийг нянгийн дэгээгээр авч түрхцийн шилэнд тойрог маягаар тараана. Түрхэцийг дөлөнд 3 сек барьж бэхжүүлнэ.
2. Түрхэц дээр кристал ягаан будаг дусааж, 60 сек үйлчилнэ.
3. Нэрмэл усаар будгийг угаана.
4. Иодын уусмалаас дусааж, 60 сек байлгана.
5. Нэрмэл усаар түрхэцийг угааж, усыг сайтар сэгсэрнэ.

6. Өнгөгүйжүүлэгч уусмал буюу этилийн спиртээр үйлчилнэ.
7. Нэрмэл усаар сайтар угаана.
8. Сафранин будгаар 60 сек будна.
9. Нэрмэл усаар будгийг угааж, шингээгч цаасаар усыг авч, тасалгаанд хатаана.
10. Микроскопоор түрхэцийг харж дүгнэхдээ эхлээд 40х объективоор будалт болон нянгийн тархацыг шалгаад дараа нь иммерсийн(100х) тосны объективоор нянг дүгнэнэ[<https://www.sigmaaldrich.com/content/dam/sigma-aldrich/docs/Sigma-Aldrich/Datasheet/1/77730dat.pdf>].

Хадгалалтын судалгааны арга зүй: Энэхүү туршилтыг эмийн хадгалах хугацааны туршилт 3, 6, 9, 12, 15, 18, 21, 24 сарын хугацаанд гүйцэтгэх бөгөөд үүнийг үндэслэн бэлдмэлийн хадгалах хугацааг тогтооно. Мөн дээрх туршилтыг эм хадгалах зохистой нөхцөл болох харанхуй, хуурай, сэрүүн газарт, тохиромжгүй нөхцөл болох гэрэлтэй тасалгаанд хадгалсан “Кюнапирамин сульфат” эмийн дээжинд гүйцэтгэн үзлээ.



LD₅₀-ийг тодорхойлох арга зүй: Шинээр гарган авсан эм болох Күйнапирамын сульфатын хурц хорон чанар буюу үхүүлэх дундаж тун (LD₅₀)– г В.Б.Прозоровский нарын (1978, 2007) хурдавчилсан аргаар сүүлний хураагуур судсаар тарьж тогтоов. Ингэхдээ 18-22 гр жинтэй 20 толгой цагаан хулгана сонгон авч туршилт эхлэхээс 24 цагийн өмнө амьтдыг байрнаас нь туршилтын өрөөнд оруулж дасгасан ба амьтдыг тэмдэглэж дугаарлан, биеийн жинг өндөр нарийвчлалтай техникийн жингээр хэмжин бүлэглэв.

Шинжилгээнд дээж авах арга зүй: Адууны гүрээний венийн судаснаас шинжэлгээнд хэрэглэгдэх цусыг EDTA хуруу шилэнд түрхэцийн шинжэлгээнд зориулан адуу тус бүрээс нэг мөн бодисгүй хуруу шилэнд ийлдэс судлалын шинжэлгээнд мөн адуу тус бүрээс нэг туюбээр цус авав. Цуглуулсан дээжээс ийлдсийг ялгаж -20⁰ С-т хадгалав.

Өвчтэй адуунд эмчилгээ хийх арга зүй: Адууны нийлүүлгийн өвчнөөр эерэг буюу өвчтэй болон сэжигтэй дүнтэй гарсан адуунд шинж тэмдэгийн болон өвчнийг эмчлэх эмчилгээг худалдаанд байгаа “ДЕМИН” (Энэтхэг улсад үйлдвэрлэсэн адууны нийлүүлгийн өвчний эсрэг) болон “Диамин ацетурат” эмтэй харьцуулан эмчилгээг 3 давталттайгаар адуу тус бүрийн амьдын жинд тохируулан эмийн зааврын дагуу тарьж эмчилгээг хийнэ. Мөн “Кюнапирамы сульфат” тарилгын уусмалыг 1, 2, 3 давталттайгаар адуу тус бүрийн амьдын жинд тохируулан эмийн заавран дагуу тарьж эмчилгээ хийсэн.


ДИАМИН АЦЕТУРАТ БОЛОН КЮНАПИРАМИН СУЛЬФАТ ТАРИЛГЫН НУНТАГ ЭМҮҮДИЙН ТЕХНОЛОГИ НУТАГШУУЛАХ ТУРШИЛТ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Кюнапирамин сульфат- Quinapyramine sulphate- ийн тарилгын уусмал бэлтгэх технологийн судалгааны дүн: Адууны нийлүүлгийн өвчний үүсгэгчийн эсрэг өндөр идэвхитэй “Кюнапирамин сульфат” -ийн 97.5 %-аас дээш цэвэршилтэй хуурай нунтагийг 2 гр аар савлан бэлтгэсэн. Уг эмийг UV гэрлээр ариутгах багажны дээрх 3 нөхцөлд 10, 15, 20 минутанд нөхцөл бүрд, минут бүрд тус бүр 5 савыг ариутгасан. Бид туршилтын цувралаар бэлтгэсэн **Кюнапирамин сульфат** агуулсан эмийг “Доур-амин” гэж нэрлэв.



3-р зураг: Савласан эмүүдийг хэт ягаан туяагаар ариутгаж байгаа нь

Уг эмийн дүүргэгч болох нэрмэл усыг 20 мл- ээр савлан автоклаваар 121°C- д 15 минут ариутган бэлтгэлээ.



4-р зураг: Эмийн найруулах дүүргэгч уусмалыг автоклавт ариутгасан байдал.

Бид адууны нийлүүлгийн өвчний үүсгэгчийн эсрэг өндөр идэвхитэй Кюнапирамин сульфат- Quinapyramine sulphate -ийн 97.5%-аас дээш цэвэршилттэй хуурай нунтаг 2 граммаар жинлэн 20мл – ын багтаамж бүхий хуванцар саванд савлан уг эмийн уусгагч шингэнийг 20 мл давхар нэрмэл усыг ариун нөхцөлд савлан бэлтгэсэн бөгөөд нийт найруулан бэлтгэсэн эмийн тоо хэмжээг 4-р хүснэгтээр харуулав.

№	Эмийн зарцуулалт	Кюнапирамин сульфат	Диамин ацетурат
1	Эмийн туршилт	40	20
2	МЭЭСБУЛ- т	8	8
3	Эмийн хадгалалт	15	15
Нийт		63	43

Кюнапирамин сурьфат агуулсан эм нийт 63 ширхэг, Диамин ацетурат агуулсан эм 43 ширхэгийг дээр дурьдснаар найруулан бэлтгэж туршилт, судалгаандаа ашиглав.

Ариун чанарын судалгааны үр дүн

Бэлтгэсэн хувилбаруудынхаа ариун чанарыг уламжлалт аргаар буюу TSA, TSB Сабуро, TG-ийн тэжээлт орчингуудыг хуруу шилэн болон петрын аяганд савлан ариутгаж эмийн ариун чанарын туршилтын ажил явагдаж байна.



5-р зураг: Тэжээлт орчингууд дээр эмийн бохирдол шалгаж буй байдал.

Ариун чанарыг уламжлалт аргаар шинжлэхэд 10, 15, 20 минут ариутгасан дээжинд ургалт илрээгүй.

Үйлчлэх хугацаа (мин)	UV гэрлийн тоо	Ариун чанарын тэжээлт орчин								Граммын арга
		Суулгац хийсэн				Хяналт				
		TSA	TSB	Сабуро	TG	TSA	TSB	Сабуро	TG	
10	1	-	-	-	-	-	-	-	-	-
	2	-	-	-	-	-	-	-	-	-
	3	-	-	-	-	-	-	-	-	-
15	1	-	-	-	-	-	-	-	-	-
	2	-	-	-	-	-	-	-	-	-
	3	-	-	-	-	-	-	-	-	-
20	1	-	-	-	-	-	-	-	-	-
	2	-	-	-	-	-	-	-	-	-
	3	-	-	-	-	-	-	-	-	-

Тайлбар: + Ургалт илэрсэн, бохир, -Ургалт илрээгүй, ариун


Туршилтанд бэлтгэсэн бүх эмүүдийн ариун чанарыг агаартан болон агааргүйтэн бактери, мөөгөнцөрийн сонгомол тэжээлт орчингууд болох TSA, TSB, Сабуро, TG гэсэн сонгомол тэжээл орчингуудад тодорхой хугацаанд байлган шалгахад бидний бэлтгэсэн эмүүд бактери, мөөгөрцөрүүд аргагүй бүгд ариун байв.

Рентген шарах төхөөрөмж (RS 1800 Q4)-өөр шарж ариутгасан дүн: Рентгэнээр шарах төхөөрөмжийн 160 KB энергитэй рентген цацрагаар 20 минут болон 25 минут бүрт 8-10 ширхэгээр савласан эмүүдийг төхөөрөмжинд хийж шарж ариутгасан.



6-р зураг: Савласан эмүүдийг хэт рентген цацрагаар ариутгаж байгаа нь

Ингээд шарж ариутгасан эмүүдийн ариун чанарыг Граммын будагдалт хийж ариун чанарыг мөн шалгав.




7-р зураг: Эмийн ариутгаж чанарыг граммын арга будаж микроскопоор шинэслэв.

Микроскопоор түрхэцийг харж дүгнэхдээ эхлээд будалт болон нянгийн тархацыг 40x өсгөлтөөр шалгасан болно. Дараа нь (100x) өсгөлтөөр нянгаар бохирлогдсон эсэхийг дурандаж харж дүгнэв. Ингэхэд Рентген туяагаар шарж ариутгахад ямар нэг нянгийн бохирдолгүй бүрэн ариутгагдаж байгааг тогтоов.

ТАРИЛГЫН НУНТАГ ЭМИЙН ХАДГАЛАЛТЫН ГОРИМЫН СУДАЛГААНЫ ДҮН

Эмийн хадгалах хугацааны туршилт 3, 6, 9, 12, 15, 18, 21, 24 саруудад эм хадгалах зохистой нөхцөл болох харанхуй, хуурай, сэрүүн нөхцөлд хадгалалтын туршилтын хийсэн.



8-р зураг: Хадгалалтын горимыг тогтоох туршилтын нөхцөл.

Энэхүү туршилтыг эмийн хадгалах хугацааны туршилтыг дээрх сарын хугацаанд тодорхой хадгалалтын нөхцөлүүдэд байлган гүйцэтгэсэн бөгөөд уг судалгааны дүнг үндэслэн бэлдмэлийн хадгалах хугацааг тогтоов. Мөн дээрх туршилтыг эм хадгалах зохистой нөхцөл болох харанхуй, хуурай, сэрүүн газарт, гэрэлтэй тасалгаанд хадгалсан “Кюнапирамин сульфат”, “Диамин ацетурат” эмүүдийн дээжинд гүйцэтгэн үзлээ.

Уг судалгааны дүнгээс харахад хадгалалтын аль ч горимд эмийг хадгалан хяналтын бүлэгтэй харьцуулахад ямар нэг өөрчлөлтгүй хэвийн байгаа ажиглагдлаа.

ҮХҮҮЛЭХ ТУНГИЙН 50% БУЮУ LD₅₀-ИЙГ ТОДОРХОЙЛСОН ҮР ДҮН:

Кўйнапирамыны сульфатын үхүүлэх дундаж тунг буюу (LD 50)–г В.Б.Прозоровскийн (1978, 2007) хурдавчилсан аргаар лабораторийн цагаан хулганад сүүлний венийн тарьж Кўйнапирамыны сульфатын үхүүлэх дундаж тунг олов.



9-р зураг: Кўйнапирамыны сульфатын үхүүлэх дундаж тунг (LD 50)–г үзсэн үр дүн

Олон улсын эмийн жагсаалтанд Кўйнапирамыны сульфатын LD₅₀- ийг Харханд арьсан доор тарихад 18 мг/кг, Хулганад хоол боловсруулах замаар олгоход 15 мг/кг, Хулганад арьсан доор тарихад 20мг/ кг, Хулганад судсаар тарихад 10мг/кг мөн Туулайд арьсан доор тарьж LD₅₀- ийг тогтооход 10мг/кг, туулайд судсанд тарихад 5 мг/кг байдаг байна.

Бидний хийсэн туршилтын дүнд кўйнапирамин сульфатын агууламж бүхий Доур-амин эмийн LD₅₀ нь лабораторийн цагаан хулганад судсаар тарьхад LD₅₀ = **1,81мг/кг** байгааг тогтоов.

Кўйнапирамыны сульфатын LD₅₀ нь судсанд тарих нь хоол боловсруулах системээр эсвэл арьсан доор тарих замаар биед орох үеийнхээс хоруу чанар өндөртэй байна[British Journal of Pharmacology and Chemotherapy., 5(25), 1950]. Гэвч цаг хугацаа хэмнэсэн цөөн тооны хулганад ашигладагаар бусад LD тогтоох аргуудаас давуу талтай юм.



КЮНАПИРАМИН СУЛЬФАТИЙН БЭЛДМЭЛИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ИДЭВХИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Байгалийн нөхцөлд *Trypanosoma equiperdum* зүйлийн эгэл биетнээр халдвар авч адууны нийлүүлгийн өвчнөөр өвчилсөн адуунд Кўйнапирамин сульфатын гол үйлчлэгч бодис бүхий эмийн эмчилгээний тунг тогтоож, эмчилгээний үр дүнг дээрх өвчний үед хэрэглэдэг бусад бэлдмэлтэй харьцуулан тооцох судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын харьяат малчин О.,- ийн адуун сүргээс нэг гүү нийлүүлгийн өвчний өвөрмөц шинж тэмдэг үзүүлэн өвчилсөн байгааг клиник шинж тэмдэг, түргэн оношлуурын тест ашиглан шинжлэхэд 2 зураас буюу өвчтэй дүн үзүүлж буйг 11-р зургаар үзүүлэв. Мөн уг шинжилгээг баталгаажуулах зорилгоор ФХЭБУ-ын


шинжилгээг лабораторит хийхэд 12-р зурагт үзүүлснээс харахад босго таньцаас дээш буюу эерэг хяналтаас өндөр гэрлийн шингээлт үзүүлж эерэг буюу өвчтэйг батлав.

ИХТ- түргэвчилсэн тестийн шинжилгээ үр дүн. ФХЭБУ-ийн шинжилгээний үр дүн



10-р зураг: Түргэн оношлуурын үр дүн. Pos- Эерэг хяналт, Neg-сөрөг хяналт, Бор гүүний дүн (өвчтэй гарсан), ФХЭБУ-н үр дүн. Pos- Эерэг хяналт, Neg- сөрөг хяналт, H-1-Бор гүүний шинжилгээний дүн

Эерэг буюу өвчтэй гарсан нэг гүүнд Кюнапирамин сульфат тарилгын нунтаг эмийг 7 хоногийн давтамжтай 2 удаа хийсэн байна. Эмчилгээний дараах үр дүнг ФХЭБУ- аар шалгаж үзэв. Эмчилгээ хийхийн өмнө OD₄₀₅ 1.121 –тэй байсан. Харин эмчилгээ хийснээс 2 сарын дараа OD₄₀₅ 0.418 болж буурсан үр дүн үзүүлэв.




1-р график: Pos- Эерэг хяналт, Neg- Сөрөг хяналт, H-1 – Эмчилгээний өмнө, H-2 - Эмчилгээний 2 сарын дараах үр дүн

Малчин О., - ын 41 адууг 3 бүлэг болгон эерэг болон сөрөг гарсан адуунд эмчилгээ болон урьдчилан сэргийлэх байдлаар Кюнапирамин сульфат тарилгын нунтаг эмийн идэвхийн судалгааг хийгдэж байна.


№	Эмчилгээний бүлэг	Эм тарисан хугацаа /цаг/		
		24	48	72
1	I-бүлэг	√		
2	II- бүлэг	√	√	
3	III- бүлэг	√	√	√

Малчин О., - ын 41 адууг 3 бүлэг болгон эерэг болон сөрөг гарсан адуунд эмчилгээ болон урьдчилан сэргийлэх байдлаар Кюнапирамин сульфат тарилгын нунтаг эмийн идэвхийн судалгааг хийсэн.



2-р график: Эмчилгээ хийхийн өмнөх ФХЭБУ-аар гарсан үр дүн

Эмчилгээний идэвхийн үр дүнг эмчилгээний 2 сар болон 4 сарын дараа ФХЭБУ-аар шалгахад босго таньцаас доош буюу сөрөг хяналттай адил гэрлийн шингээлт үзүүлж сөрөг буюу эрүүлийг батлав. 12-р зурагт болон 5-р хүснэгтэнд харуулав.



3-р график: Эмчилгээ хийсний 4 сарын дараах ФХЭБУ-аар гарсан үр дүн


Диамин ацетурат агуулсан эмээр эмчилгээ хийсэн бүлгийн адууны эмчилгээний дараах үр дүнг Фермент холбох эсрэгбиеийн урвалаар эмчилгээний дараа цусны ийлдсэнд үүссэн эсрэгбиеийн титрээр хянаж эмчилгээний үр дүнг гаргалаа. Эмчилгээний 24, 48, 72 цагийн зайтай тарилт хийсэн эмийн бүлгүүд бүгд босго таньцаас доогуур буюу эрүүл болж эсрэгбиеийн титр буурсан байна.

Хүснэгт 7

Эмчилгээний үр дүнг ФХЭБУ-аар хянав.						
№	Малын зүс	Бүлэг	Шинжилгээний арга			
			ФХЭБУ			
			Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа		
				2 сар	4 сар	1 жил
			OD ₄₀₅ нм	OD ₄₀₅ нм	OD ₄₀₅ нм	OD ₄₀₅ нм
1	Хүрэн байдас	I-р бүлэг	+++0.3649	0.0606	0.0152	0.0190
2	Хонгор азарга		+++0.2010	0.0367	0.0494	0.0533
3	Зээрд гүү Цоорхой		+++0.1610	0.0532	0.0150	0.0252
4	Хул гүү Хүзүүвчтэй	II-р бүлэг	+++0.5589	0.0895	0.0527	0.0522
5	Хар бор гүү		+++0.2870	0.0384	0.0094	0.0196
6	Хонгор гүү		+++0.1684	0.0265	0.0066	0.0288
7	Хар гүү	III-р бүлэг	+++0.4375	0.0798	0.0479	0.0574
8	Хул азарга		+++0.3250	0.0428	0.0175	0.0298
9	Пони хар гүү		+++0.1850	0.0298	0.0231	0.0440

Малчин Ч.-ын 11 адуунд ДИАМИН АЦЕТУРАТ /туршилтын эм/ болон ДЕМИН /худалдааны эм/ эмийг харьцуулан туршилт хийж цус ийлдсийн дээж авч эмчилгээний үр дүнг 2 сар болон 6 сарын дараа ФХЭБУ-аар шалгахад босго таньцаас доош буюу сөрөг

хяналттай адил гэрлийн шингээлт үзүүлж сөрөг буюу эрүүлийг батлав. 14-р зурагт болон 6-р хүснэгтэнд харуулав.




4-р график: Малчин Ч., - ын эерэг гарсан 6 адуунд эмчилгээ хийсний 6 сарын дараах ФХЭБУ-аар гарсан үр дүн

Адууны нийлүүлгийн өвчний халдварын шатуудаас мөн тухай бодьгалийн биемахбодийн онцлог зэргээс хамааран эсрэгбиеийн титрийн хөдлөл зүй харилцан адилгүй байлаа. Эмчилгээ хийснээс 2, 6, 12 сарын дараа тухай малд үүссэн эсрэгбиеийн титрээр эмчилгээний үр дүнг хянасан юм.

Хүснэгт 8

Эмчилгээний үр дүнг ФХЭБУ-аар хянав.						
№	Малын зүс	Бүлэг	Шинжилгээний арга			
			ФХЭБУ			
			Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа		
				2 сар	6 сар	1 жил
			OD ₄₀₅ нм	OD ₄₀₅ нм	OD ₄₀₅ нм	OD ₄₀₅ нм
1	Хул байдас	I-р бүлэг	+++0.1748	0.0406	0.0378	0.0594
2	Хонгор		+++0.2795	0.0267	0.0235	0.0115
3	Халиун		+++0.1960	0.0432	0.0475	0.0067
4	Зээрд	II-р бүлэг	+++0.1954	0.0595	0.0482	0.0384
5	Хүрэн сартай		+++0.2395	0.0384	0.0395	0.0215
6	Өсгий цагаан хонгор		+++0.2021	0.0235	0.0205	0.0452

Эмчилгээ хийгээгүй хяналтын бүлэг: Байгалийн нөхцөлд *T. equiperdum*- ийн халдвар авч өвчилсөн нутгийн Монгол гүүнд эмчилгээ хийгээгүй бөгөөд Мал эмнэлгийн хүрээлэнгийн том амьтны туршилтын байранд явууллаа. Судалгаа эхэлсэн эхний долоо хоногоос хойш нийт 12 долоо хоногийн турш авсан ийлдсэнд ФХЭБУ тавьж үүсгэгчийн эсрэг үүссэн эсрэг биеийн титрийг шалгасан үр дүнг 6-р графикаар харууллаа.



5-р график. *T. equiperdum*- ийн халдвартай гүүний ийлдсэн дэх эсрэг биеийн титр.

Дээрх үр дүнгээс харахад *T. equiperdum*- ийн халдвартай гүүнд эсрэг биеийн титрийн хэмжээ тогтвортой өндөр хэвээр байлаа.

T. equiperdum- ийн халдвартай гүү их хэмжээгээр турж эцэх, цус багадах, нүүрний хэсэгчилсэн саажилт болох чих, доод уруул унжсан, дээд уруул болон хамар нэг тал руугаа мурийх, орон зайн баримжаагаа алдах, буруу талын нүдэнд эвэрлэг эд үүссэн, хойд хоёр хөл дотогшоо мурийсан, зүүн талын хондлойн булчин хатингаршсан зэрэг клиник эмнэл зүйн шинж тэмдэг илэрч байгааг 11-р зурагт үзүүлэв.



11-р зураг. Байгалийн нөхцөлд *T. equiperdum*- ийн халдварт авч өвчилсөн гүүнд илэрсэн эмнэл зүйн шинж тэмдэг. А. Судалгаа эхлэхийн өмнөх *T. equiperdum*- ийн халдвартай гүү, Б. Нүүрний хэсэгчилсэн саажилт, В. Баруун талын нүдэнд эвэрлэг үүссэн эвэрлэг эд, Г. Хойд хоёр хөл дотогшоо мурийсан, Д. Хондлойн булчин хатингаршсан, Е. 12 долоо хоногийн дараах *T. equiperdum*- ийн халдвартай гүү.

T. equiperdum- ийн халдвар авч өвчилсөн гүүнд 12 долоо хоногийн турш судалгаа шинжилгээний ажил явуулсны дараа энэхүү гүүг нядалж эерэг ийлдэс гаргаж авах мөн эмгэг материалыг авч эмгэг бие бүтцийн хувиралтыг шинжлэх цаашдын судалгаанд ашиглав.

Энэхүү төслийн явцад үйлдвэрлэсэн кюнапирамин сульфат агуулсан эм, диамин сульфат агуулсан дээрх 2 эм нь адууны нийлүүлгийн өвчний халдварын эхний шатанд хавсарсан эмчилгээ хийхэд өндөр үр дүнтэй байгааг тогтоосон. Уг төслийн явцад эмчилгээний судалгааны үр дүнгээрээ олон улсын импакт фактортой сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн болно. Өгүүлэлийг Journal of equine veterinary science сэтгүүлийн 87-р дугаарт 2020 оны 4-р сард хэвлүүлснийг 5-р хавсралтаар харуулав.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ

1. Орчин үеийн оношлуур болох рекомбинант эсрэгтөрөгч бүхий ФХЭБУ-ын оношлуурын цомгийг үйлдвэрлэж УМЭАЦТөв лаборатори болон аймаг, нийслэлийн мал эмнэлгийн 22 лабораториудад төслийн хугацаанд нийт 32 цомгийг нийлүүлсэн.
2. Сум орон нутгийн мал эмнэлгийн нэгжийн эмч нар ашиглах боломжтой түргэвчилсэн оношлогооны төстийг төслийн нийт хугацаанд 13000 ширхэгийг үйлдвэрлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2019 онд 6000 ширхэг, 2020 онд 6430 төслийн хугацаанд нийт 12430 оношлуурыг нийлүүлсэн байна.

3. Адууны нийлүүлгийн өвчний тархалт болон халдварлалт өндөртэй аймаг, сумын 200-аас доошгүй ширхэг түргэн оношлуурыг сумын мал эмнэлгийн нэгж болон хувийн мал эмнэлэг, малын эмч нарт нийлүүлэв.
4. Адууны нийлүүлгийн өвчнийг эмчлэх импортын эм бэлдмэлүүдтэй ижил үйлдэл бүхий эмийн бэлдмэл үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэхээр кюнапирамин сульфатыг гол үйлчлэгч бодис бүхий эмийн технологийн туршилтыг хийж гүйцэтгэж байна. Дээрх эмийн туршилтын загваруудыг Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторит шалгуулсан бөгөөд цаашид уг эмийн Мал эмнэлгийн үйлдвэрлэгчийн Фармакопейн өгүүлэлийг бичиж, МЭЕГ-н дэргэдэх фармакопейн хороогоор хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.
5. Төв аймаг болон Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын (малчин О, Ч, Б нарын) нийт 450 адуунд нийлүүлгийн өвчний урьдчилан сэргийлэлт болон эмчилгээ хийх зорилгоор “Тридамон” эмийг зах зээлд нэг адууны эмчилгээг 10000 төгрөгийн өртөгийн хийв. Зах зээлд байгаа ижил төрлийн үйлчилгээтэ эм болох Демин эм нь 1 адууны эмчилгээнд 15000-20000 төгрөг, Неодизин эм нь 1 адууны эмчилгээнд 20000- 25000 төгрөгийн өртөгтэй байна.

ФХЭБУ- ийн цомгийн Сорилтын дүн, шинжээчийн дүгнэлт (2020 оны цуврал)

МЭЭСБҮЛ УГҮГ-ийн Засварын 2020 оны 03-р сарын 16-ны өдрийн
А/36 тоот тушаалаар баталсан. Мэвгт №11/01



"МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН
СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН
УЛСЫН ЛАБОРАТОРИ" УГУГ

Монгол улс, УБ хот, Хан-Уул дүүрэг, 12-р хороо, Солонго
Харинцах утас: 7049-2942, Факс: 7049-2942

СОРИЛТЫН ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/ : 20-362

Шинжилгээ хийгч хүсэлт гаргасан газрын нэр : Гарваны вебнотех
/The name of customer's request for analysis/

Дээжийн тэдэрхийлэлт /Sample description/					
Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цувралын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer	Хуучингэй хугаанаа Expire date	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
365	Нийлүүдлийн өвчний үүсгэгч T. equiperdanti- ийг оношлох ФХЭБУ- ын цомог	001-р	Монгол Улс / МУ/	2020/06/02 - 2021/06/02	1 цомог

Хүлээн авсан өгнөө Date of receipt	Шинжилгээ дууссан өгнөө Date of test completion	Хэвлэсэн өгнөө Date of issue of the report
2020 он 06 сар 04 өдөр	2020 он 06 сар 17 өдөр	2020 он 06 сар 23 өдөр

Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжээ нэгж Test parameter, unit	Шаардлага Test specification, unit	Шинжилгээний дүн Test results
365	Дагалдах НТББ, МЭУФӨ-.....төсөл	Оношлуурын цомог	ФХЭБУ-ын цомог	ФХЭБУ-ын цомог
	Дагалдах НТББ, МЭУФӨ-.....төсөл	Оношлуурын галдагч байдал	Тусгай хайриагт савлагдан битүүмжлэгдсэн	Тусгай хайриагт савлагдан битүүмжлэгдсэн
	Дагалдах НТББ, МЭУФӨ-.....төсөл	Оношлуурын бүрдэл	Рекombinant эсрэгтөрөгч суулгасан ФХЭБУ-ын 96 үүр бүхий полистрол хавтан, угаагч уусмалын пунтаг, хяналтын эсрэг ийлдэс, хяналтын сөрөг ийлдэс, 2 догч эсрэгбием буюу коньюгат, субстрат ABTS-ийн шахмал болон уусгах буфер зэргээс бүрдэнэ.	Рекombinant эсрэгтөрөгч суулгасан ФХЭБУ-ын 96 үүр бүхий полистрол хавтан, угаагч уусмалын пунтаг, хяналтын эсрэг ийлдэс, 2-догч эсрэгбием буюу коньюгат, субстрат ABTS-ийн шахмал болон уусгах буфер зэргээс бүрдсэн
	Дагалдах НТББ, МЭУФӨ-.....төсөл	Бөгсө танд /405 нм гэрлийн долгионы уртад уширна/	Сөрөг хяналтын ийлдэс ≤ 0.15 Сөрөг хяналтын ийлдэс ≥ 0.15	Сөрөг хяналтын ийлдэс 0.018 эсрэг хяналтын ийлдэс 0.75



**"МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН
СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН
УЛСЫН ЛАБОРАТОРИ" УТҮГ**

Монгол улс, УБ хот, Хаш-Уул дүүрэг, 12-р хороо, Сонгино
Харуулах утас: 7049-2942, Факс: 7049-2942

**БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБАНЫ
ЭКСПЕРТИЙН ДҮГНЭЛТ
CONCLUSION OF CERTIFICATION EXPERT**

Бүртгэлийн дугаар /Registration number/ : 20-362

Олгосон : 2020 он 06 сар 23 өдөр
/Date of issue/

Зориулалт : /Purpose/ : Цувралын шалгалт /Дотоод/

"Гарааны ветбиотех" ААН/УТҮГ-ийн үйлдвэрлэсэн "Нийлүүлгийн өвчний үүсгэгч T. equiperdum-ийг оношлох ФХЭБУ-ын цомог" оношлогооны бэлдмэл-ийн/ын 40 цомог бүхий 001-р цувралын дээж нь сорилтын лабораторийн 20-362 тоот дүнгээр Дагалдах НТББ, МЭҮФӨ-.....төсөл -ийн шаардлагыг хангаж байна.

Сорилтын 20-362 дугаартай дүнг хэвсэргэв.

Дүгнэлт гаргасан:

Чанарын баталгаажуулалтын Эксперт:




гарын үсэг/signature/

/П.Нямсүх /

ФХЭБУ- ийн цомгийн Сорилтын дүн, шинжээчийн дүгнэлт (2019 оны цуврал)

МЭЭСБУД-ийн Засварын 2017 оны 08-р сарын 03-ны өдрийн
А/18 тоот тушаалаар баталж. Мангуй №22/01



**“МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН
СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН
УЛСЫН ЛАБОРАТОРИ” УТГ**

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 12-р хороо,
Сонгино. Нарилгах утас: 7049-2942

СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ДҮН

Дугаар №2019/553 Олгосон 2019-08-22
он.сар.өдөр

Дээжийг ирүүлсэн газрын нэр: Баталгаажуулалтын алба
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал: Эксперт Л. Нямсүх

Протоколын дугаар	Бүтээгдэхүүний стандартын дугаар	Дээжийн тодорхойлолт
H-0925-19	МЭУФӨ- ийн төсөл	Адууны нийлүүлгийн өвчнийг оношлох ФХЭБУ-ын цомог 003 -р цуврал

Шинжилгээнд ирүүлсэн дээжийн тоо, хэмжээ	Дээж хүлээн авсан огноо	Шинжилсэн огноо
1 цомог	2019-08-20	2019-08-20 2019-08-22

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Шаардлага	Үр дүн
Оношлуурын цомог	ФХЭБУ-ын цомог	ФХЭБУ-ын цомог
Оношлуурын гадаад байдал	Тусгай хайрцагт савлагдсан битүүмжлэгдсэн.	Тусгай хайрцагт савлагдсан битүүмжлэгдсэн.
Оношлуурын бүрдэл	Рекомбинант эсрэгтөрөгч суулгасан ФХЭБУ-ын 96 үүр бүхий полистрол хавтан, угаагч уусмалын нунтаг, хяналтын эерэг ийлдэс, хяналтын сөрөг ийлдэс, 2 догч эсрэгбием буюу коньюгат, субстрат АВТС-ийн шахмал болон уусгах буфер зэргээс бүрдэнэ.	Рекомбинант эсрэгтөрөгч суулгасан ФХЭБУ-ын 96 үүр бүхий полистрол хавтан, угаагч уусмалын нунтаг, хяналтын эерэг ийлдэс, хяналтын сөрөг ийлдэс, 2 догч эсрэгбием буюу коньюгат, субстрат АВТС-ийн шахмал болон уусгах буфер зэргээс бүрдсэн.
Босго таньц (405 нм гэрлийн долгионы урт)	Сөрөг хяналтын ийлдэс ≤ 0.15 Эерэг хяналтын ийлдэс ≥ 0.15	Сөрөг хяналтын ийлдэс 0.01 Эерэг хяналтын ийлдэс 0.55

Энэхүү шинжилгээ нь лабораторийн ISO/IEC17025:2007 стандартын дагуу MNAS итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн ба зөвхөн шинжилгээ хийсэн сорьцод хамаарна. Шинжилгээний дүн лабораторийн зөвшөөрөлгүй хэсэгчлэн болон бүхэлд нь хуулбарлахыг хориглоно.

Нүүр хуудас 1/2

МЭЭСБУЛ-ийн Захирлын 2017 оны 10-р сарын 30-ны өдрийн
Б/15 тоот тушаалаар батлав



Хан-Уул дүүрэг 12-р хороо
Утас 70492942

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН
СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН
УЛСЫН ЛАБОРАТОРИ**



**ИТГЭМЖЛЭГДСЭН БАТАЛГААЖУУЛАЛТЫН
АЛБАНЫ ЭКСПЕРТИЙН ДҮГНЭЛТ**

Дугаар № Д\05\0626

Олгосон: 2019-08-22

"Гарааны ВетБиоТех" ХХК-ний үйлдвэрлэсэн "Адууны нийлүүлгийн
өвчнийг оношлох ФХЭБУ-ын цомог"-ын 1000 тун бүхий 003-р цувралын дээж
нь сорилтын лабораторийн 2019/553 тоот дүнгээр оношлуурын цомог,
оношлуурын гадаад байдал, оношлуурын бүрдэл, босго таньц үзүүлэлтүүд
МЭУФӨ-ийн төсөлд заасан үзүүлэлт, шаардлагыг хангаж байна.

Сорилтын 2019/553 тоот дүнг хавсаргав.

Дүгнэлт гаргасан:

Чанарын баталгаажуулалтын эксперт



Л. Нямсүх

Түргэн оношлуурын Сорилтын дүн, шинжээчийн дүгнэлт (2020 оны цуврал)

МЭЭСБЭЭН УТҮГ-ийн Төвлөлийн 2020 оны 03-р сарын 15-ны хурлын
436 тоот тулгамдур бичиг



"МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН
СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН
УЛСЫН ЛАБОРАТОРИ" УТҮГ

Министрийн Угсаа Хамруулах, Хүн Ажил, 12-р хороо, Сангийн
Хөгжил үйлдвэр: 7909-2942, Факс: 7909-2942

БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЛБАНЫ
ЭКСПЕРТИЙН ДҮГНЭЛТ
CONCLUSION OF CERTIFICATION EXPERT

Бүртгэлийн дугаар /Registration number/: 20-354

Олгосон : 2020 он 06 сар 22 өдөр
/Date of issue/

Зориулалт: /Purpose/: Цувралын шагналт /Дотоод/

"Гарааны ветбиотех" ААН/УТҮГ-ийн үйлдвэрлэсэн "Адууны нийлүүлгийн өвчний түргэн оношлуур" оношлогооны бэлдмэл-ийн/ын 10000 ширхэг бүхий 001-р цувралын дээж нь сорилтын лабораторийн 20-354 тоот дүнгээр МЭУФӨ-11.220-00232-18 -ийн шаардлагыг хангаж байна.

Сорилтын 20-354 дугаартай дүнг хавсаргав.

Дүгнэлт гаргасан:
Чанарын баталгаажуулалтын Эксперт:


гарын үсэг/signature/

Л.Нямсүх /



**"МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМНИЙ
 СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН
 ХИСЛЭН ЛАБОРАТОРИ" УГУУ**

Монгол улс, Увс айм, Ховд сум, 12-р хороо, 1 багцны
 Хэргийн урсгал: 7045-2942, Факс: 7046-2942

**СОРИЛТЫН ДҮН
 CERTIFICATE OF ANALYSIS**


Бүртгэлийн дугаар (Registration number) : 20-354

Шинжилгээний үйлдвэр хүсэлт гаргасан газрын нэр : Үарааны нөсөөтөх
 /The name of customer's request for analysis/

Дэвсгэлийн тэдгээрийн түүстэй (Sample description)					
Дэвсгэлийн дугаар Sample number	Дэвсгэлийн нэр Name of sample	Цууригтай дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacture	Хувицтай хугацаа Expiry date	Дэвсгэлийн тоо хэмжээ Quantity of the sample
357	Адууны шийвэрлэлийн өсгийг тургал өмчлүүр	301-р	Монгол Улс / МУ	2020/06/01 - 2020/06/02	1 нэгж
Хугацаа алсан огноо Date of expiry		Шинжилгээ дууссан огноо Date of test completion		Хэвлэсэн огноо Date of issue of the report	
2020 оны 05 сар 01 өдөр		2020 оны 05 сар 17 өдөр		2020 оны 05 сар 22 өдөр	

Дэвсгэлийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилгээний үзүүлэлтийн нэр, хэмжээ нэгж Test parameter, unit	Шийрэгжилт Test specification, unit	Шинжилгээний дүн Test results
357	МЗУ 060-11.220-02232-18	Өмчлүүрэн хэвцэг	Ивчлүүрэнхөнгөргөлийн түүстэй	Ивчлүүрэнхөнгөргөлийн түүстэй
	МЗУ 060-11.220-02232-18	Үр дүрт	Зөвөг илрэхэд өөрөг (1) , өөрөг илрэхэд (-) үр дүрт үзүүлэлт	Зөвөг илрэхэд 2 хувиас, өөрөг илрэхэд 1 хувиас
